



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.17 № 03/84

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий 2012 он, 2013 оны эхний 9 дугаар сарын санхүүгийн зарим үйл ажиллагаанд эрсдлийн аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 2005 онд “Жугамт” ХХК-д 90 хоногийн хугацаатай 100.0 сая төгрөгийн “Энгийн Вексель” бичиж гаргасан бөгөөд тус компани 2000 тн хаягдал төмөр нийлүүлэх гэрээ байгуулсан боловч гэрээнд тусгагдсан хаягдал төмрийг өнөөдрийг хүртэл нийлүүлээгүй бөгөөд гэрээний дагуу 2013 оны 09 дүгээр сарын 30-н хүртэл алдангийг тооцвол 8,0 сая, үлдэгдэл төлбөр 59,0 сая, нийт 67,0 сая төгрөг төлүүлээгүй байна.

Энэ нь тус компанитай байгуулсан 2005/6-10 дугаар гэрээний 3-д бэлтгэн нийлүүлэгч нь гэрээнд заасан хугацаанд багтаж хаягдал төмрийг нийлүүлэх үүргийг хүлээнэ. Хугацаа хэтэрсэн хоног тутамт 0,8 хувийн алданги тооцох нийт торгууль нь үнийн дүнгийн 8 хувиас хэтрэхгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...” гэж заасныг үндэслэн **АКТ ТОГТООХ НЬ:**

“Жугамт” ХХК-иас хаягдал төмрийн үнэ ба алданги 67,0 сая төгрөгийг гаргуулан авч, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны харилцах дансанд гэрээ дуусах хугацаа буюу 2014 оны 3 дугаар сарын 30-ны дотор төвлөрүүлэх,



АКТЫГ

ТОГТООСОН:

ҮАГ-ЫН АУДИТОР

*Ш.ОТГОНБАЯР*  
Ш.ОТГОНБАЯР  
УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙ  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ЭДИЙН  
ЗАСАГ ХАРИУЦСАН ОРЛОГЧ

*Б.АЛТАНХУЯГ*  
Б.АЛТАНХУЯГ  
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ  
ПЛАТОНОВ М.В

070307